

“САРУУЛ ОЮУТНЫ ХҮЗҮҮНИЙ ЧИМЭГ” ТОЛЬ БИЧГИЙН ОНЦЛОГ

Д.Бүрнээ

Түлхүүр үг: хуучин үгийн толь, нэг хэлний толь, үсэг дараалуулсан толь, үг хэллэгийн тайлбар, зээлдсэн үг, шаашин соёлын холбоот үг

Төвөд хэлээр уламжилж ирсэн буддын шашны болон төрөл бүрийн эрдэм ухааны ном судрыг монгол түмэнд хүргэхэд толь бичиг чухал үүрэг гүйцэтгэж иржээ. Толь бичгийг төвөд хэлээр “даяг”¹ гэж нэрлэх бөгөөд монгол хэлнээ “дохионы бичиг” гэж хөрвүүлнэ. Энэ үгийг бид төвөд хэлнээс зээлж, төвөд-монгол хоёр хэлний толийг “даяг” гэж нэрлэж заншжээ. Харин “даг-ег”² хэмээх нэр томъёог “тогтоосон даг ег” гэж орчуулж нэр томъёоны шинжтэй толь бичгийг нэрлэж байжээ. Тухайлбал, “Мэргэд гарахын орон” толь бичиг бол ийм нэртэй. Буддын шашны утга зохиолын их, бага арван ухааны нэр томъёоны орчуулгыг журамласны учир тийнхүү “тогтоосон” гэж нэрлэсэн байна.

Монгол толь бичгийн хөгжлийн түүхэнд буддын утга зохиолыг судлах, орчуулахад зориулж найруулсан төвөд-монгол толь бичиг олон бий. Бидэнд мэдэгдэж буйгаар хамгийн эртний төвөд-монгол дохионы бичиг бол Брова равжамба Гунгаажамцын 1718 онд зохиосон “Нарны гэрэл”³ хэмээх төвөд-монгол хоёр хэлний толь буюу орчуулгын толь юм. Тус толиос хойш олон арван дохионы бичиг гарч өнөө үед уламжилж иржээ. Монголчуудын найруулсан толь бичгүүдийг гадаад орны толь зүйчид өргөн ашиглаж ирсэн уламжлал бий. Тухайлбал, Я.Шмидт, Ф.Голстунский, О.Ковалевский, Ю.Н.Рерих нарыг дурдаж болох юм. Энэ нь монголчууд төвөд хэлнээс буддын шашны утга зохиолыг бүр 13-14-р зуунаас орчуулж ирсэн баялаг туршлагатай төдийгүй олон арван толь бичиг найруулж, тэдгээртээ шашны элдэв зүйл нэр томъёог монгол хэлнээ орчуулах арга зүйг тогтоосон учир тийнхүү буддын шашны утга зохиолыг төвөд хэлнээс европ дахины хэлэнд орчуулахад монголчуудын туршлага чухал дэм болж байсантай холбоотой.

Дохионы бичгүүдийн дотор орчуулгын толиос гадна нэр томъёоны, хэл сурах, тайлбар, хэлний зүй, шинэ хуучин дохионы, ёгт нэрийн гээд олон төрлийн толь бичиг байсныг дурдаж болох юм. Эдгээр толь бичиг хэмжээний тухайд том, дунд, бага янз бүр байхаас гадна гар бичмэл болон нутаг нутгийн бар хэвлэлээр уламжилж иржээ. Монгол толь зүйчдийн дунд олон дохионы бичиг туурвиж, төвөд-монгол толь зүйн түүхэнд чухал үүрэг гүйцэтгэсэн хэлний зүйч бол Алшаа нутгийн Агваандандар лхаарамба юм. Төвөд хэлээр эрдэм ухааны олон салбараар бичсэн дөч гаруй, монголоор “Хэлний чимэг” хэмээх монгол хэлшинжлэлийн дурсгал бичиг зохиосныг бид мэднэ. Тэр бээр нийт гурван толь бичиг найруулснаас 1838 онд нас сүүдэр наятайдаа бичсэн “Сарны гэрэл” хэмээх төвөд-монгол дохионы бичиг нь монголчуудын дунд их танил болж, хэдэн зууны туршид төвөд болон монгол толь зүйчид

¹ Төвөд хэлээр “brda yig”.

² Төвөд хэлээр “dag yig” буюу орчуулбал “ариун бичиг” гэсэн үг.

³ Төвөд хэлээр “nyi ma'i 'od”.

ашигласаар ирсэн уламжлалтай. “Сарны гэрэл”-ээс гадна Агваандандарын бичсэн хоёр дахь толь “Үүрийн туяа”⁴ хэмээх нэртэй (Бүрнээ, 2004:74-78). Уг толь зөв бичих дүрмийн толь бөгөөд бичлэг дуудлага төстэй боловч утгын ялгаатай буюу ижил үг, утга ойролцоо төвөд үгсийн толь гэж хэлж болно. Бидний энэхүү өгүүлэлд авч үзэх Агваандандарын гурав дахь толь бол “Саруул оюутны хүзүүний чимэг”⁵ гэсэн нэртэй. 2000 гаруй толгой үгтэй багавтар хэмжээний толь юм. Тус толийн дараах хэдэн онцлогийг энд авч үзнэ. Үүнд:

1. Цагаан толгойн үсгийн дарааллаар найруулсан төвөд-төвөд буюу нэг хэлний толь болох нь

“СОХЧ” хэмээх толь “Цастан төвөдийн шинэ хуучин дохионоос найруулсан дохионы бичиг саруул оюутны хүзүүний чимэг”⁶ хэмээх нэртэй. Уг толийг Агваандандар зохиохдоо Жогдон лозава Ринчендашийн 1536 онд бичсэн “Лишийн орд харш”⁷ хэмээх шинэ, хуучин үг хэллэгийн толь болон Агваанчойжижамцын 1538 онд зохиосон “Мэргэдийн хэлний зул” хэмээх зөв бичих дүрмийн толийг ашигласан тухайгаа төгсгөлийн үгдээ дурджээ. “Лишийн орд харш” төвөд хэлээр гар бичмэл болон бараар тархжээ. Тус толийн монгол орчуулга хадсан гар бичмэл болон бар хэвлэл ч гадаад дотоодын номын сангуудад тааралддаг. Монгол орчуулгыг урад гүүш Билигийн Далай төвөд хэлнээс орчуулсан нь хоёр хэлний толь бичгийн журмаар хэрэглэх эх үүсвэрийг тавьсан байна. Тус тольд толгой үгийг цагаан толгойн дарааллаар бичээгүй бөгөөд зарим үгд санскрит бичлэг хадсан байхаас гадна толгой үгийг товч тайлбарлажээ. “Мэргэдийн хэлний зул”⁸ тольд монголчууд орчуулга хадаж төвөд-монгол толь бичгийн журмаар ашиглаж байжээ. Энэ хоёр толь аль аль нь үсэг дараалуулан бичих журмыг мөрдөөгүй бөгөөд Агваандандар “СОХЧ” тольдоо шинэ хуучин үг хэллэгийг жагсаахдаа төвөд цагаан толгойн дарааллыг баримталсан нь ашиглахад амар хялбар болгосон давуу талтай. Агваандандар толийнхоо нэрийг шинэ хуучин дохионы бичиг гэж нэрлэж байгаа ч толгой үгд хуучин үгийг оруулж, тайлбарлах зарчимаар бичсэн тул төвөд хэлний хуучин дохионы товч тайлбар толь гэж үзэж болох юм.

2. Олон сурвалж бичиг ашиглаж тайлбарласан нь

Өмнө дурдсан шинэ-хуучин дохионы толь болох “Лишийн орд харш”-ийн тайлбарт ямар сурвалж ашигласныг дурдаагүй бол Агваандандарын тольд ном судрын нэрийг тодорхой заан тэмдэглэжээ. Тайлбар хийхэд ашигласан ном судрыг бүртгэвэл зуу орчим болж байна. Эдгээр нь буддын шашны гол гол хөлгөн судар байхаас гадна төвөд утга зохиолд нэрд гарсан зохиол байгаа юм. Энэ нь уг толийн тайлбарыг ул үндэстэй, баримттай болохыг харуулна. Өмнө гарсан тольд ороогүй толгой үгийг нэмэн оруулахаас гадна тодорхой зохиолоос эшилж дэлгэрүүлэн тайлбарласныг харж болох юм. Тухайлбал, “жингор”⁹ буюу хадны гүрвэл, цастны мэлхий гэсэн үгийг “нүхэнд орших амьтан буюу дажид гүрвэл ч гэж хэлсэн бий. “Лайчоог сэрдог”-т халиу хэмээсэн буй”¹⁰ гэж тайлбарлажээ (Агваандандар, 2014:37). Толгой үгд санскрит хэлнээс зээлдсэн үг оруулсан байх бөгөөд тэдгээрийн зөрөөтэй орчуулгыг бас

⁴ Төвөд хэлээр “skya rengs gsar ba”.

⁵ “СОХЧ” гэж товчлоно. Төвөд хэлээр “blo gsal mgrin rgyan”.

⁶ Төвөд хэлээр “Gangs can gyi brda’ gsar rnying las brtsams pa’i brda’ yig blo gsal mgrin can ces bya ba bzhugs so” гэсэн нэртэй.

⁷ Төвөд хэлээр “Li shi gur khang”.

⁸ Төвөд хэлээр “Bod kyi brda’i bye brag gsal bar byed pa’i bstan bcos tshig le’ur byas pa mkhas pa’i ngag gi sgron ma”, монголоор “Töbed-ün dokiyen-u ilyal-i todudqan üyiledügci šastir üges-I bölüglen üyiledügßen merged-ün kelen-ü jula”.

⁹ Төвөд хэлээр “skyin gor”.

¹⁰ Төвөд хэлээр “srog chags khung na gnas pa dang da byid yin zhes bshad pa yod kyang las chog nam rgyal gser mdog las sram yin par bshad do”.

дурдсан байна. Тухайлбал, “гаадамба” гэсэн санскрит гаралтай үгийг “цахлай хэмээх боловч “Янжанжэйлу” сударт цууцаль гэсэн буй”¹¹ гэжээ. Өөрөөр хэлбэл, энэ үгийн орчуулга зөрж буйг тэмдэглээд “Сарны гэрэлд”-д “цахлай” гэж орчуулснаас үзвэл “цууцаль” гэсэн тайлбартай санал нийлээгүй болох нь харагдаж байгаа юм.

“Ga gon” гэсэн толгой үгийг “хар тугалга, бас манжин гэсэн утгатай. “Намдэл дига чэн риг би жамц”-д га гон-ыг боловсорсон жимсний үрийн шүүс, олон өвчин анагаадаг” гэжээ¹². Энэхүү “ga gon” гэсэн толгой үгийг Агваандандар “Сарны гэрэл”-дээ зөвхөн “хар тугалга, манжин” гэсэн утгаар авахын сацуу уламжлалт анагаах ухаанд бас хэрэглэдэг болохыг таниулсан байна.

3. Бусад толь бичгийн хэрэглэгдэхүүн болсон нь

Хожим XX дугаар зуунд гарсан төвөд-монгол, төвөд-төвөд, төвөд-англи, төвөд-хятад зэрэг толь бичгийн хэрэглэгдэхүүн болсон байна. Тус толийн дотор хуучирсан хэлц үг цөөнгүй орсон байх бөгөөд тэдгээрийн тайлбарыг үзвэл хожмын толь бичгүүдэд хуулбарлан авсан, засан найруулсан, нэмэн дэлгэрүүлсэн ажээ. Тухайлбал:

“Сарны гэрэл”	“Саруул оюутны хүзүүний чимэг”	“Харанхуйг арилгагч зул” ¹³
Кье’u sus <i>Ilegüü idekü</i>	Khye’u sus ni bsod snyoms su mi gtogs pa’i bza’ bca’ phran bu sger du bcos pa’i ‘di la zhal ‘tshus kyang zer. Yang na nar mar za tshod las lhag par za ba yin par <u>kun mkhyen, mtsho sna ba’i ‘dul TI ka las</u> bshad	Khye’u sus ni bsod snyoms su mi gtogs pa’i bza’ bca’ phran bu sger du bcos pa’i ‘di la zhal ‘tshus kyang zer. Yang na nar mar za tshod las lhag par za ba yin par bshad <i>Binvad tur orolčayadüi eker siker idegen umdayan tuqayilan jasanya egün-i joγoγ ču gedeg, ese bögesü yerüde-yin idegen-ü kemjiyel- eče ülemji idekü mön geju nomlaysan</i>

Binvad-tur orolčayadüi eker siker idegen umdayan tuqayilan jasanya egün-i joγoγ ču gedeg, ese bögesü yerüde-yin idegen-ü kemjiyel-eče ülemji idekü mön geju nomlaysan

Энэ хүснэгтээс харвал Сумадираднаа Агваандандарын тайлбараас зохиогч Гүнчэн Цонавын нэр болон “Дүлдига” хэмээх зохиолын нэрийг хасаж бусад тайлбарыг тольдоо хуулбарлан авч орчуулжээ. Ийм жишээ цөөнгүй бий.

4. Шашин соёлын холбоотой үг хэллэгийг тайлбарласан нь

Тус толийн дотор Төвөдийн аж амьдрал, зан заншил, шүтлэг бишрэл цаашлаад хоол хүнс, дээл хувцас, орон гэр болон ан амьтан, өвс ургамал, жигүүртэн шувууг нэрлэсэн олон уугуул төвөд үгээс гадна санскрит, монгол гаралтай үг хэллэг оржээ. Санскрит хэлнээс гаралтай үг хэллэгийн дотроос “банзалига” хэмээх үгийг “Алэн буюу Таван авалга хэмээх орноос гарсан бөсийн нэр” гэж тайлбарлажээ. Энэ үг монгол хэлэнд “банзал” хэмээх хэлбэрээр орсон бөгөөд Д.Төмөртоогоо энэ үгийг “анхандаа Хималайн уулын бэл дэх Панчала гэдэг газар нэхсэн давууг нэрлэж байгаад хожим лам хүн доод биеэ ороож өмсдөг нэгэн зүйлийн хувцасыг ийн нэрлэх болжээ. Эдүгээ эмэгтэй хүн доод биедээ углаж өмсдөг хувцасыг нэрлэж байна. Доогуураа задгай, тайлахад хялбар тус хувцасны нэр нь хожим “завхай зайдан гэсэн шилжсэн утгаар хэрэглэгдэх болсон” гэж тайлбарласан байна (2018:41-42).

¹¹ Төвөд хэлээр “ka dam pa ni chu skyar yin zhes bshad kyang sbyangs can dgyes gkur mthin ril du bshad”.

¹² Төвөд хэлээр “ga gon no zha nya nag po ste nyung ma la yang ‘jug. Yang na nram ‘grel Ti ka chen rigs pa’i rgya mtsho las ga gon ni shing tog ‘bras bu chen po smin pa na ro skyur nan na khu ba mang po ‘du ba’i nad phal che ba la gnod pa’o”.

¹³ Сумадираднаагийн 1877 онд зохиосон төвөд-монгол дохионы бичгийн нэр.

Агваандандарын толиос эл үгийн төвөд бичлэгээр уламжилж ирсэн хувилбар болох “банзалига” нь Панчала хэмээх санскрит үгийн хөрвүүлэг бөгөөд орчуулбал “Таван авалга” гэсэн утгатай болохыг мэдэж авч болно. Энэ үгийн бичлэг монгол хэлнээ зээлдсэн “банзал” гэсэн хувилбартай төстэй болохыг харж болох юм. Нөгөөтэйгүүр, энэ үг бол санскрит хэлнээс төвөд болон монгол хэлнээ Энэтхэгийн шашин соёлын холбоотой ижил төрлийн үг зээлдсэн байдгийн нэг тодорхой жишээ юм.

“СОХЧ”-ийн дотор төвөд болон монгол хэлнээ тааралдах “завхрал” (tsab hral) гэдэг үгийг Агваандандар “ekene-ün aburi jadayaırayısan” гэж орчуулаад “ариун явдал доройтсоноос хүссэнээ өгүүлж, олны дунд шуугиан тарихыг хэлнэ. Дэлээ босгох ч гэнэ. Биеийн завхрал нь инээдэмтэй болой” гэж тайлбарлажээ. “Завхрал” хэмээх үгийг Сумадираднаагийн тольд “садар ааль” гэсэн байна. О.Сүхбаатарын “Монгол хэлний харь үгийн толь”-д “их тачаалт сэтгэлээс болж сэртгэнтэн ааш авир задгайрсан нь. Гэлэнмаа нарын бүдүүн гэм хийгээд тойдын дүр байдал доройтон хурьцлыг шүтэн зөөлөн наалинхай, ичгүүргүйгээр явж толгойгоо чичигнүүлэх, үе гишүүнээ хөдөлгөн, үгсээ эндүүрэх зэрэг бие хэлний авир аашлал гэж хуучин судар бичигт тэмдэглэсэн буй” гэж тайлбарласан байх бөгөөд цааш нь уг үг шилжсэн утгандаа “хүний ажил явдал буруудах гажуу сөргүү болсон нь” гэж тайлбарлаад энэ үгийг төвөд гаралтай гэж тэмдэглэжээ. Д.Төмөртоого “завхрал” гэсэн үгтэй ижил язгууртай “зав, завсар, завх, завхай, завхар” зэрэг үгийг тоочсоноос үзвэл энэ үг монгол гаралтай үг бас байж болох талтай. Төвөд бичгийн хэлнээ эл үгийн бичлэг ойролцоо хоёр хувилбар уламжилж ирсэн байх бөгөөд монголоор ижил дуудна. Үүнд “tsab hral” хэмээх үг орчин цагийн төвөд хэлнээ “тэнүүлч, тэнэмэл, тэнүүчлэх” гэж байгаа бол нөгөө бичлэг ойролцоо “rtsab hral” хэмээх үгийг “Төвөд-хятад их толь бичиг”-т “ариун явдлаа доройтуулагчийг муушаах үг” гэжээ (2013:2215). Гэвш Чойдагийн “Нэр үг тодорхой” хэмээх тольд “явдал мөр муу гэсэн үг. Монгол хэлнээ завхай гэнэ” гэжээ (1981:680). Гэвш Чойдаг бол Төвөдөд олон жил суусан монгол хүн учраас монгол хэлээр оноож бас бичсэн байна. Ийнхүү муушаасан утга бүхий энэ үг төвөд хэлнээс орж ирсэн бололтой.

“СОХЧ”-т орчин цагийн төвөд толь бичигт тэмдэглээгүй хуучирсан утгыг тайлбарласан байгаа нь Төвөдийн шашин соёлын холбоотой үг хэллэгийг өнөөгийн хүмүүс мэдэж авах, төвөд хэлний түүхэн үгийн сангийн судлалд чухал үүрэгтэй болохыг харуулж байна. Тухайлбал, “жан” гэдэг үгийг “сав эдлэл, Лхасын ерөөлийн манз зөөх мөнгөн буюу зэс чимэгт сав” гэж тус тольд бичжээ. “Төвөд-хятад их толь”-д “цай архи тэргүүтэн унд зөөх сав суулгын нэгэн зүйл” (2013:99), Ю.Н.Рерих “хүрэл суулга, хүрэл хумх” гэжээ (1983:140). Бид Агваандандарын тайлбараас эл үг анх түрүү Лхасын ерөөлийн их хурлаар хэрэглэж байсан, мөнгө болон зэсээр үйлдсэн, бас хээ хуартай байсан тэргүүтнийг олж мэдэж байна.

Төвөд үндэстний сэтгэлгээний онцлогийг харуулсан хэлц үг тус тольд цөөнгүй бий. Тухайлбал, “glo ba la gsags pa” гэсэн хэлцийг үгчилж орчуулбал “уушгинд хадгалах”, “уушгинд хоногших” гэж буй. Агваандандар “Сарны гэрэл”-дээ “сэтгэлдээ хадгалсан” гэж орчуулж, “СОХЧ”-тээ төвөд хэлээр “yid la gsags pa’o” гэж бичжээ. Монгол хэлэнд бас уушигтай холбоотой хэлц үг бий. Тухайлбал, өнөөдрийн уушгиас маргаашийн өөх, ам нээвэл уушги нээ гэх мэт. Аливаа хэлэнд хүний сэтгэл хөдлөлийг бие эрхтэнтэй холбож илэрхийлэх нь түгээмэл. Тухайлбал, “элэг” хэмээх үг итали хэлэнд эр зоригийг заасан хэлц үгийг үүсгэдэг бол хятадын уламжлалт анагаах ухаан болон итгэл бишрэлд “элэг”-ийг уур хилэн, шунал тачаалын голомт гэж үзэж байжээ. Япон хэлэнд бол мэдрэх эрхтнийг бэлгэдэх ажээ (Маслова, 2001:82). Төвөд хэлээр баярлахыг “уушгиа баясгах” гэж хэлдэг (Рерих, 1984:129).

5. Толь бичгийг зохиосон оны тухай

Тус толь бичгийг хэдэн онд зохиосон талаар Агваандандар дурдсангүй. “Сарны гэрэл” толь бичгийг 1838 онд зохиохоос өмнө буюу хойхно их ойрхон зохиосон бололтой. Энэ хоёр толь хоорондоо их холбоотой. “СОХЧ”-т орсон хэлц үгийн орчуулгыг “Сарны гэрэл”-ээс харж болно. Тухайлбал, “pyi lang byed pa” гэсэн толгой үгийг “urida-yin gem deger-e daqin gem üyiledkü” гэж орчуулаад, “СОХЧ”-т “урьд гэм үйлдсэн дээрээ дахин гэм үйлдэхийн нэр” гэж тайлбарлажээ. “Byu ru lugs su bshad pa” гэсэн хэлц үгийг “Сарны гэрэл”-д “siluyun yosun-iyar nomlaysan” гэж орчуулан, “СОХЧ”-т “stan por smra ba’i don” буюу “шудрага өгүүлсэн утга” гэж тайлбарлажээ. Өөрөөр хэлбэл, “Сарны гэрэл”-ийн бэлэн орчуулгыг нэг бол төвөд хэл рүү хөрвүүлсэн, эсвэл “СОХЧ”-ээс авч монголчилсон бололтой.

6. Толь бичгийн эхлэл болон төгсгөлийн үгийн тухай

Толь бичгийн эхэнд Агваандандараас өөрийн багш Лондол лам Агваанлуvsан, улмаар бурхан Будда, Манзуширт мөргөсөн мөргөлөөр эхэлж, толь бичгээ зохиох болсон тухайд “урьдын мэргэд дохионы шастир хэсэг бусаг утга хураангуй зохиосон бөгөөд тэдгээрээс сайны хувийг түүвэрлэж, дутууг нөхөн гүйцээж, мэргэдийн чуулганыг гийгүүлэхийн тулд гали үсгийн эрхэсээр жигдлэн найруулав” гэж зорилго болон арга зүйгээ тодотгон бичжээ.

Төгсгөлийн үгийг төвөд шүлгийн үе тэнцүүлж 9 үеэр мөрийг жигдлэн шүлгэлсэн нь

Ертөнцийн нүд болсон наран, усан тэнгэрт

Ер цастаны дохионы мунхаг үгсийн харанхуй үүл бүрхэв

Идэр залуу саруул оюутан төөрч будилах энэ цагт

Шинийн саран мэт энэ ариун дохио урган мандав

гэж бичээд төвөдийн дохионы бичиг болох “Лишийн орд харш”, “Мэргэдийн хэлний зул” болон хэдэн арван зохиолыг ашиглан “өөр болон бусдад туслах сэтгэлээр найруулсан” хэмээн дурдсан байна.

Дүгнэлт

Ийнхүү Агваандандарын бичсэн “Саруул оюутны хүзүүний чимэг” хэмээх толь тус толь өмнө гарсан “Лиш гүр хан”, “Мэргэдийн хэлний зул” тольтой харьцуулахад толгой үгийг цагаан толгойн дарааллаар жагсааж үг хайж олоход амар хялбар болгосон, үг хэллэгийг тайлбарлахад ашигласан сурвалж бүрийн нэрийг тэмдэглэсэн, Төвөдийн түүх шашин соёлын холбоотой үг хэллэгийг багтааснаар онцлог бөгөөд нэн ялангуяа санскрит болон монгол хэлнээс зээлдсэн үг хэллэг орсон байгаа нь энэтхэг, төвөд, монгол орны утга соёлын холбоог харуулах баримт болж буй тухайд ач холбогдолтой.

Агваандандар өөрийн зохиосон “Сарны гэрэл” болон “Саруул оюутны хүзүүний чимэг” толь бичгээ “даяг” хэмээн нэрлэсэн, харин “Үүрийн туяа” толь бичгээ “даг ег” гэснийг анхаарууштай. Сүүлийн толь бол зөв бичих дүрмийг журамласан толь учраас тийнхүү “ариун бичиг” буюу “даг ег” гэжээ. Харин өмнөх хоёр толь бичиг бол толгой үгийг орчуулсан хийгээд тайлбарласан толь учраас “дохионы бичиг” гэж нэрлэсэн байна. Сонирхолтой нэг зүйл бол төвөд толь зүйчид толь бичгээ “даяг” хэмээн нэрлэж байгаагүй бөгөөд энэ нэрээр хэлний зүйгээ нэрлэж байжээ. Тэгэхээр “даяг” хэмээх үг бол монгол толь зүйчдийн хоёр хэлний болон нэг хэлний толийг тусгайлан нэрлэж байсан нэр томьёо бөгөөд орчин цагийн монгол хэлнээ эл үгийг “төвөд-монгол орчуулгын толь” гэсэн утгаар хэрэглэх болжээ.

Агваандандарын “Саруул оюутны хүзүүний чимэг” толь бол хуучин дохионд шинэ дохио дүйлгэж тайлбарласан нэг хэлний толь бөгөөд тус толийг БНХАУ-д хэвлэн нийтэлж, төвөд

судлаачид ашигласаар байгаа нь төвөд судлалд монгол эрдэмтний аль 19 дүгээр зуунд бичсэн толь бичиг өнөөдөр ч үнэ цэнээ алдаагүй байгааг илтгэн харуулж байна.

Abstract

For centuries, Mongols have used reference books or dictionaries as a handbook when translating books and sutras on Buddhism. This article investigates the different features of the dictionary called "Intelligent Person's Necklace" (Intelligent Person's Necklace Elegant Pearl Rosary) written by Agvaandandar of Alashaa (1759-1840), a lexicographer of the 19th century, and identifies its differences by comparing pre and post dictionaries in terms of methodologies. This dictionary arranges headwords in the order of the Tibetan alphabet and as well as uses source texts to explain the words. The explanation is believed to play an important role in studying the relationship between lexicography and literature.

Номзүй

Агваандандар. 2014. Gangs can gyi brda' gsar rnying las brtsam pa'i brda' yig blo gsal mgrin can ces bya ba bshugs so (Цастан Төвөдийн шинэ хуучин дохионоос түүвэрлэн найруулсан дохионы бичиг саруул оюутны хүзүүний чимэг). Bod kyi brda sprod phyogs bsgrigs bzhugs so (Төвөдийн хэлний зүйн шастирын эмхтгэл). Pod nyes lnga pa brda gsar rnying skor, Si khron mi rigs dpe skrun khang, shog 34-106.

Агваандандар. 1838. brda' yig ming don gsal bar byed dpa'i zla ba'i 'od snang zhes bya ba bzhugs so (Нэр утгыг тодотгогч Сарны гэгээн гэрэл хэмээгдэх дохионы бичиг оршив). Хятад барын судар.

Жогдон лозава Ринчендаш. 2014. Bod kyi skad las gsar rnying gi brda'i khyad par ston pa legs par bshad pa li shi'i gur khang zhes bya ba bzhug (Төвөдийн хэлнээс шинэ хуучин дохионы ялгалыг үзүүлэгч сайн номлол лишиний орд харш хэмээх оршив). Bod kyi brda sprod phyogs bsgrigs bzhugs so (Төвөдийн хэлний зүйн шастирын эмхтгэл). Pod nyes lnga pa brda gsar rnying skor, Si khron mi rigs dpe skrun khang, shog 138-161.

Агваанчойжижамц. 2014. Bod kyi brda'i bye brag gsal bar byed pa'i bstan bcos tshig le'ur byas pa mkhas pa'i ngag gi sgron ma". (Төвөдийн дохионы ялгалыг тодотгон үйлдэгч шастир үгсийг бүлэглэн үйлдсэн шастир мэргэдийн хэлний зул). Pod nyi shu pa dag yig gi skor, Si khron mi rigs dpe skrun khang, shog 1-35.

Бүрнээ Д. 2004. Агваандандарын "Үүрийн шинэхэн туяа" хэмээх толь бичгийн онцлог, Улаанбаатар дээд сургууль эрдэм шинжилгээний бичиг. Уб. Дугаар 02/03, х.74-78.

Маслова В.А. 2001. *Лингвокультурология, учебное пособие*. Москва, 204 стр.

Рерих Ю.Н. 1983-1984. *Тибетско-русско-английский словарь с санскритскими параллелями*. Выпуск 1-2.

Сүхбаатар О. 2014. *Монгол хэлний харь үгийн толь*. Адмон. 280х.

Төмөртоогоо Д. 2018. *Монгол хэлний үгийн гаралын тайлбар толь*. Уб., Адмон. 444х.

Bod rgya tshig mdzod chen mo [Төвөд хятад их толь]. 2013. Pe cin mi rigs dpe skrun khang. Sdod cha. 1604х.